

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2017 оны...дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ХҮНИЙГ ЗАХИРГААНЫ ЖУРМААР АЛБАДАН ЭМЧЛЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь согтуурах, мансуурах донтой хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтад авч, захиргааны журмаар албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх хууль тогтоомж

2.1.Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх хууль тогтоомж нь Эрүүл мэндийн тухай¹, Архидан согтуурахтай тэмцэх тухай², Сэтгэцийн эрүүл мэндийн тухай³, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль⁴, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Албадан эмчлэх үндэслэл

3.1.Согтуурах, мансуурах донтой болох нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураар эмчлүүлэхээс татгалзсан бол уг этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулна.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан донтох эмгэгийн оношийг тогтооход эрүүл мэндийн салбарт мөрдөж байгаа оношлогоо, эмчилгээний стандарт, удирдамжийг баримтална.

3.3.Жирэмсэн хүн, гурав хүртэл насны хүүхэдтэй эх, 16 насанд хүрээгүй хүн,

¹ Төрийн мэдээлэл 2011 №21

² Төрийн мэдээлэл 2000 №6

³ Төрийн мэдээлэл 2013 №3

⁴ Төрийн мэдээлэл 2002 №8

65-аас дээш настай хүн болон албадан эмчилгээ хийхэд харшлах өвчин эмгэгтэй хүнийг албадан эмчлэхийг хориглоно.

4 дүгээр зүйл.Албадан эмчлүүлэх тухай хүсэлт гаргах

4.1.Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлүүлэх тухай хүсэлтийг дараахь этгээд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад /цаашид “цагдаагийн байгууллага” гэх/ гаргана:

- 4.1.1.өрхийн болон сумын эмч, эсхүл сэтгэц, наркологийн эмч;
- 4.1.2.сум, хорооны нийгмийн ажилтан;
- 4.1.3.байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага;
- 4.1.4.гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн.

4.2.Албадан эмчлүүлэх тухай хүсэлтийг тухайн хүн өөрөө, эсхүл нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын алба хаагч санаачлан гаргаж болно.

5 дугаар зүйл.Эрүүл мэндийн байгууллагын дүгнэлт гаргуулах

5.1.Цагдаагийн байгууллага энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан хүсэлтийг хүлээн авмагц тухайн хүний хувийн баримт бичиг, тодорхойлолтыг бүрдүүлж, энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан дүгнэлт гаргуулахаар эрүүл мэндийн байгууллагад хандана.

5.2.Эрүүл мэндийн байгууллага тухайн хүнийг согтуурах, мансуурах донтой эсэхийг тодорхойлсон дүгнэлтийг үзлэг хийснээс хойш 24 цагийн дотор гаргаж өгнө.

5.3.Согтуурах, мансуурах донтой эсэх дүгнэлт гаргахад шаардагдах зардлыг тухайн эрүүл мэндийн байгууллага хариуцаж, үзлэг шинжилгээг үнэ төлбөргүй хийж үйлчилнэ.

5.4.Эрүүл мэндийн байгууллага дүгнэлт гаргахдаа тухайн хүн согтуурах, мансуурах донтой эсэх, уг эмгэгийг эмчлэхэд харшлах өвчин, эмгэгтэй эсэхийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээгээр тогтоож хэрэв өвчин эмгэгтэй бол хориглох заалт, хүндрэл, гаж нөлөөг дүгнэлтэд зааж, албадан эмчилгээнд явуулахыг хориглох эсэх тухай тодорхой бичнэ.

5.5.Согтуурах, мансуурах донтой хүнд албадан эмчилгээ хийхэд харшлах өвчин эмгэгийн жагсаалт, эрүүл мэндийн байгууллагын дүгнэлт гаргах журам, эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтийн загварыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

5.6.Энэ хуулийн 5.2-т заасан дүгнэлтийг тухайн хүн, түүний гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн эс зөвшөөрвөл Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх төв байгууллагад хандан гомдол гаргаж болно.

6 дугаар зүйл.Сайн дураараа эмчлүүлэх хүсэлт гаргах

6.1.Согтуурах, мансуурах донтой гэсэн дүгнэлт гарсны дараа тухайн хүн өөрөө сайн дураараа эмчлүүлэх хүсэлтээ цагдаагийн байгууллагад бичгээр гаргавал албадан эмчилгээнд явуулахгүй.

6.2.Хүсэлт гаргасан хүн хүсэлт гаргасан өдрөөс хойш нэг сарын хугацаанд эмчилгээнд хамрагдаагүй бол энэ хуулийн 4.2-т заасны дагуу цагдаагийн байгууллага тухайн хүнийг албадан эмчилгээнд явуулах саналыг шүүхэд гаргана.

7 дугаар зүйл.Лавлагаа, тодорхойлолт авах

7.1.Цагдаагийн байгууллага шаардлагатай тохиолдолд албадан эмчилгээнд явуулах хүний талаар улсын бүртгэлийн байгууллагад хандаж лавлагаа, тодорхойлолт гаргуулна.

7.2.Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 7.1-д заасан лавлагаа, тодорхойлолтыг үнэ төлбөргүй, даруй гаргаж өгнө.

8 дугаар зүйл.Шүүхэд хүсэлт гаргах

8.1.Цагдаагийн байгууллага доор дурдсан материалыг бүрдүүлж, албадан эмчилгээнд явуулах хүнийг шүүхэд шилжүүлнэ:

8.1.1.тухайн хүнийг албадан эмчилгээнд явуулах тухай энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан хүсэлт;

8.1.2.албадан эмчилгээнд явуулах хүний иргэний үнэмлэхний, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар, байхгүй тохиолдолд иргэний бүртгэлийн байгууллагын лавлагаа;

8.1.3.оршин суугаа газрын хаягийн тодорхойлолт;

8.1.4.тухайн хүн согтуурсан, мансуурсан үедээ зөрчил гаргасан, эсхүл эрүүлжүүлэгдсэн бол энэ тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

8.1.5.тухайн хүн согтуурах, мансуурах донтой тухай эрүүл мэндийн байгууллагын дүгнэлт.

8.2.Шүүх энэ хуулийн 8.1-д зааснаас бусад материалыг холбогдох байгууллага, иргэдээс шаардан авч болно.

9 дүгээр зүйл.Шүүх шийдвэр гаргах

9.1.Тухайн хүнийг албадан эмчилгээнд явуулах эсэхийг шүүх хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

9.2.Шүүх хуралдааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явуулж, шийдвэр гаргана.

9.3.Шүүх хуралд албадан эмчилгээ хийлгэх хүнийг өөрийг нь болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, албадан эмчилгээнд явуулах хүсэлт гаргасан хүн, цагдаагийн байгууллагын төлөөлөл, шүүхээс шаардлагатай гэж үзсэн бусад хүнийг оролцуулж болно.

9.4.Шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлнэ.

9.5.Тухайн хүн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааны дотор давж заалдах гомдол гаргах эрхтэй.

9.6.Албадан эмчлэх тухай шүүхийн шийдвэр гарах хүртэл хугацаанд шаардлагатай тохиолдолд тухайн хүнийг саатуулах, шүүхийн шийдвэр гарсны дараа албадан эмчлэх эмнэлэгт хүргэх ажиллагааг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

10 дугаар зүйл.Эмнэлэгт хүлээн авах

10.1.Албадан эмчлүүлэх хүнийг хүлээж авахдаа эмнэлэг доор дурдсан баримт бичгийг шаардана:

10.1.1.шүүхийн шийдвэр;

10.1.2.эрүүл мэндийн байгууллагын дүгнэлт;

10.1.3.иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг, байхгүй тохиолдолд иргэний бүртгэлийн байгууллагын лавлагаа.

10.2.Эмчлүүлэх хүний биед болон эд зүйлд ижил хүйсийн харуул хамгаалалтын ажилтанг байлцуулан үзлэг хийж, хориглосон баримт бичиг, мөнгө, эд зүйлийг бүртгэн түр хурааж авна.

10.3.Эмчлүүлэх хүнийг хүлээж авмагц түүнд үзлэг хийн, өвчний түүх нээж, албадан эмчилгээний зорилго, ач холбогдол, эмнэлгийн дотоод журам, эмчлүүлэгчийн эрх, үүргийг танилцуулна.

10.4.Хэвтэн эмчлүүлэх өрөөнд хүйсийн байдлаар нь хуваарилах ба анх удаа эмчлүүлэгчийг давтан ирж байгаа эмчлүүлэгчээс тусад нь байрлуулна.

10.5.Согтуурах донтой хүнийг мансуурах донтой хүнтэй нэг өрөөнд байрлуулахыг хориглоно.

10.6.Албадан эмчлэх эмнэлэгт хүлээж авах үед эмчлүүлэхээр ирсэн хүн нь хууль ёсны асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй, гэр оронгүй, ажил эрхэлдэггүй нь тогтоогдож байгаа бол Албадан эмчлэх эмнэлэг энэ хүний тухай мэдээллийг нийгмийн халамж, үйлчилгээний асуудал хариуцсан байгууллагад эмчлүүлэгчийг эмнэлэгт хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор хүргүүлнэ.

10.7. Нийгмийн халамж, үйлчилгээний асуудал хариуцсан байгууллага нь энэ хуулийн 10.6-д заасан Албадан эмчлэх эмнэлгийн мэдээллийн дагуу тухайн хүнийг судалж, эмнэлгээс гарахад нь иргэний улсын бүртгэлд бүртгүүлэх, ажилд зуучлах, нийгмийн халамжид хамруулах арга хэмжээ авна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Албадан эмчлэх эмнэлэг

11 дүгээр зүйл. Албадан эмчлэх эмнэлэг

11.1. Албадан эмчлэх эмнэлэг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяалалд ажиллана.

11.2. Албадан эмчлэх эмнэлгийн даргыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

11.3. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан эмнэлгийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

11.4. Албадан эмчлэх эмнэлэг нь төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг байх ба түүнийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэрийг Засгийн газар гаргана.

11.5. Албадан эмчлэх эмнэлэг нь согтуурах, мансуурах донтой хүнд холбогдох хууль, журам, стандартын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

11.6. Албадан эмчлэх эмнэлэг нь шүүхийн шийдвэрийг үндэслэн эмчлүүлэх хүнийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй хүлээн авна.

11.7. Албадан эмчлэх эмнэлэг нь өөрийн үйл ажиллагааны чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнтэй хамтран ажиллаж болно.

11.8. Албадан эмчлэх эмнэлгийн дотоод журмыг эмнэлгийн дарга батална.

11.9. Албадан эмчлэх эмнэлэг, түүний алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой энэ хуульд тусгаагүй бусад асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүл мэндийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

12 дугаар зүйл. Мэргэжлийн удирдлага

12.1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх төв байгууллага согтуурах мансуурах донтой хүнийг албадан эмчлэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1. албадан эмчлэх эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх,

давтан сургах ажлыг зохион байгуулах, эмнэлгийн мэргэжилтнээр хангах ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх;

12.1.2.эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хяналт тавих;

12.1.3.оношлогоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл болон холбогдох бусад техник хэрэгслээр хангахад туслалцаа үзүүлэх, тэдгээр нь эрүүл ахуйн болон стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавих;

12.1.4.эмчилгээний арга барилыг сайжруулах, үр дүнг тооцох, энэ чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгүүлэх, цаашид баримтлах бодлогыг тодорхойлох;

12.1.5.албадан эмчлэх эмнэлгийн үйл ажиллагааг бусад эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах;

12.1.6.шаардлагатай бол эмчлүүлэгчийг төрөлжсөн эмнэлгийн үйлчилгээнд хамруулах;

12.1.7.хуульд заасан бусад.

12.2.Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.3.Албадан эмчлэх эмнэлгийн байр болон эмнэлгийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, стандартыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Стандартчилал тохирлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу батлуулна.

13 дугаар зүйл.Албадан эмчлэх эмнэлгийн харуул хамгаалалт

13.1.Албадан эмчлэх эмнэлгийн аюулгүй байдал, харуул хамгаалалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

13.2.Албадан эмчлэх эмнэлгийн харуул хамгаалалтын журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга Улсын ерөнхий прокурортой хамтран баталж мөрдүүлнэ.

13.3.Эмчлүүлэгч албадан эмчлэх эмнэлгээс оргосон тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага эрэн сурвалжлах ба шаардлагатай бол цагдаагийн байгууллагаас туслалцаа авна.

14 дүгээр зүйл.Санхүүжилт

14.1.Албадан эмчлэх эмнэлгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд уг зардалд тухайн хүнд илэрсэн бусад өвчнийг эмчлэх, нөхөн сэргээх тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн хувцас, өвчний байдлаас шалтгаалж өгөх эмчилгээний хоолны болон албадан эмчлэх газарт хүргэх, эмчилгээ дууссаны дараа буцаах зэрэг зардлыг оруулж тооцно.

14.2.Албадан эмчлэх эмнэлгийн санхүүжилтэд Архидан согтуурахтай тэмцэх сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр байж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Албадан эмчилгээ

15 дугаар зүйл.Албадан эмчилгээ хийх

15.1.Албадан эмчилгээг тухайн өвчний үед баримталдаг эмчилгээний аргачлал, стандартын дагуу явуулах ба дараахь зарчмыг баримтална.

15.1.1.хүний эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандах;

15.1.2.эмчлүүлэгчийн нууцыг хадгалах;

15.1.3.зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт болон улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, бэлдмэлийг хэрэглэх.

15.2.Албадан эмчилгээг байнгын харуул хамгаалалт бүхий эмнэлэгт явуулна.

15.3.Албадан эмчлэх эмнэлэг эмчлүүлэгчид зайлшгүй шаардлагатай шинжилгээ, эмчилгээг стандартын дагуу хийж, албадан эмчилгээний явцыг өвчний түүхэнд үнэн зөв, тодорхой бичнэ.

15.4.Эмчлүүлэгч эмчилгээ хийлгэхээс татгалзвал түүнд харуул хамгаалалтын ажилтны хяналтад эмчийн заавраар албадан эмчилгээг хийж, энэ тухай өвчний түүхэнд тэмдэглэнэ.

15.5.Эмчлүүлэгч өөртөө болон бусдад аюултай үйлдэл хийж болзошгүй байдалд орсон тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан журмын дагуу тусгаарлах болон номхотгох аргыг хэрэглэж болно.

15.6.Албадан эмчлүүлж байгаа хүнд сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээг цогц байдлаар үзүүлнэ.

15.7.Сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээний хүрээнд явуулах нөхөн сэргээх хөдөлмөр эмчилгээ нь эмчлүүлэгчийн биеийн байдал, мэргэжил, хөдөлмөрийн чадвар, нас биеийн онцлогт тохирсон байна.

15.8.Албадан эмчлэх эмнэлэг нь эмчлүүлэгчийн донтох эмгэгийг эмчлэхийн зэрэгцээ тухайн хүний биед илэрсэн бусад өвчин эмгэгийг эмчлэх ба тус эмнэлэгт эмчлэх боломжгүй нөхцөлд эмчлүүлэгчийг зохих эмнэлэгт шилжүүлнэ.

16 дугаар зүйл.Эмчлүүлэгчийн эрх, үүрэг

16.1.Эмчлүүлэгч дараахь эрхтэй:

16.1.1.эмнэлгийн дотоод журамтай танилцах;
16.1.2.эмнэлгийн шаардлагатай эмчилгээ үйлчилгээ авах;
16.1.3.эрүүл ахуйн шаардлага хангасан ахуй нөхцөл, эмчилгээний дэглэмд зохицсон хоол хүнсээр хангуулах;
16.1.4.эмнэлгийн дотоод журамд хориглоогүй хувцас, хэрэглээний эд зүйл, хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх;
16.1.5.гэр бүлийн хүмүүстэйгээ чөлөөтэй уулзах, эргэлт авах, захиа бичих, утсаар ярих;
16.1.6.хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах;
16.1.7.эмнэлгийн үйл ажиллагаа, эмчилгээ, шинжилгээний талаар санал өгөх, гомдол гаргах;
16.1.8.ар гэрт нь гачигдал, зовлон учирсан болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар тус эмнэлгийн дотоод журамд заасны дагуу чөлөө авах.

16.2.Эмчлүүлэгч дараахь үүрэгтэй:

16.2.1.эмнэлгийн дотоод дүрэм, журмыг мөрдөх;
16.2.2.албан хаагчдын хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
16.2.3.стандартын дагуу шаардлагатай оношлогоо, эмчилгээ хийлгэх;
16.2.4.сэтгэц нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээ, хөдөлмөр эмчилгээнд хамрагдах.

17 дугаар зүйл.Албадан эмчлэх хугацаа

17.1.Албадан эмчилгээг эмчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний үр дүнгээс шалтгаалан гурваас зургаан сар хүртэл, давтан эмчлүүлэх тохиолдолд зургаан сараас нэг жил хүртэл хугацаатай хийнэ.

17.2.Албадан эмчлэх хугацаа нь эмчлүүлэгчийн эмчилгээний үр дүнг харгалзан мэргэжлийн эмч нарын зөвлөгөөний дүгнэлтийг үндэслэн гаргасан шүүхийн шийдвэрээр дуусгавар болно.

17.3.Албадан эмчлэх эмнэлэг нь эмчилгээнд харшлах өвчин эмгэг илэрсэн нөхцөлд эмчлүүлэгчийн эмчилгээг зогсоох тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болно.

18 дугаар зүйл.Албадан эмчлэх эмнэлгээс гарах

18.1.Албадан эмчлэх эмнэлэг нь эмчлүүлэгчийн эмчилгээ дууссан тухай мэдээллийг эмчлүүлэгчийн харьяалах нутаг дэвсгэрт орших эмнэлгийн сэтгэц, наркологийн эмч, сэтгэц наркологийн эмч байхгүй нөхцөлд өрхийн, эсхүл сумын эмч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад эмчилгээний хугацаа дуусахаас долоо хоногийн өмнө хүргүүлнэ.

18.2.Шүүхийн шийдвэрийн дагуу албадан эмчилгээний хугацаа дуусч эмнэлгээс гарч байгаа хүнд түр хураан авсан баримт бичиг, мөнгө, эд зүйлийг бүртгэлийн дагуу буцааж өгнө.

18.3.Албадан эмчлэх эмнэлэг нь эмнэлгээс гарч байгаа эмчлүүлэгчид бататгах эмчилгээнд хэрхэн хамрагдах болон цаашид анхаарах асуудлын талаар тодорхой бичсэн санамж бичиг гардуулж, агуулгыг нь тайлбарлаж өгнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

19 дүгээр зүйл.Сургалтад хамруулах

19.1.Эзэмшсэн мэргэжилгүй, ажилгүй эмчлүүлэгчдэд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулж болно.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан сургалтыг явуулах тохиолдолд дараахь шаардлагыг харгалзана:

19.2.1.эмчлүүлэгчийн эмчилгээний горим, үр дүн, биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;

19.2.2.сургалтын үргэлжлэх хугацаа нь эмчлүүлэгчийн эмчилгээний хугацаанд багтсан байх;

19.2.3.сургалтын үр дүнд албан ёсны мэргэжлийн үнэмлэх олгох;

19.2.3.сургалт явуулах байгууллага нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан шаардлагыг хангасан байх;

19.2.4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу сургалтын төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийн сангаас санхүүжүүлэх.

19.3.Албадан эмчлэх эмнэлэг нь эмчилгээний хугацаа дууссаны дараа сургалтад хамрагдсан хүнийг эзэмшсэн мэргэжлийнх нь дагуу ажлын байранд зуучлах ажлыг хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, үйлчилгээний асуудал хариуцсан байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

20 дугаар зүйл.Ажилд нь эргүүлэн авах

20.1.Аж ахуйн нэгж, байгууллага албадан эмчилгээнд хамрагдсан хүнийг эмчлүүлж байх хугацаанд ажлын байрыг нь хадгалж, эмчилгээ дууссаны дараа ажилд нь эргүүлэн авах үүрэгтэй.

21 дүгээр зүйл.Бататгах эмчилгээнд хамрагдах

21.1.Албадан эмчлэх газарт эмчлүүлсэн хүн эмчилгээ дууссаны дараа оршин суугаа нутаг дэвсгэрт байрлах эмнэлгийн сэтгэц, наркологийн эмчид, сэтгэц наркологийн эмч байхгүй нөхцөлд өрхийн, эсхүл сумын эмчид бүртгүүлэн эмчилгээний заавар, стандартын дагуу бататгах эмчилгээнд хамрагдана.

21.2.Энэ хуулийн 21.1-д заасан эмч, тухайн засаг захиргааны нэгжийн нийгмийн ажилтан хариуцан бататгах эмчилгээнд хамрагдаж байгаа хүнд зориулан нийгэм, хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг

тухайн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран явуулж болно.

22 дугаар зүйл.Гомдол гаргах

22.1.Албадан эмчлүүлж байгаа хүн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч албадан эмчлэхтэй холбогдсон гомдлыг шүүхэд гаргаж болно.

23 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

23.1.Энэ хуулийг 2018 оны .. дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ